

STUDIA ARCHAEOLOGICA  
INSTITUTI HISTORIAE ET ARCHAEOLOGICI  
ACADEMIAE SCIENTIARUM MONGOLICI

---

---

Tomus XXXVII

2018

Fasciculus 1-18

# АРХЕОЛОГИЙН СУДЛАЛ

Эрхэлсэн: доктор, дэд профессор Ч.Амартүвшин

УЛААНБААТАР  
2018

DDC  
930.1'015  
А-779

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн  
Эрдмийн зөвлөлийн баталснаар хэвлэв.

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

Редакцийн зөвлөлийн дарга: Д.ЦЭВЭЭНДОРЖ  
Нарийн бичгийн дарга: Ц.Төрбат

Ч.Амартүвшин, Я.Бемманн (ХБНГУ), Вэй Цзян (БНХАУ), Б.Гүнчинсүрэн, А.П.Деревянко (ОХУ), Ч.Ёрөөл-Эрдэнэ, И Сон-бук (БНСУ), Ц.Төрбат, В.Ханичёрч (АНУ), Б.Цогтбаатар, Я.Цэрэндагва, Н.Шираиши (Япон), У.Эрдэнэбат, Г.Эрэгзэн

Археологийн судлал

Боть XXXVII, дэвтэр 1-18, Улаанбаатар хот, 2018 он

Эрхэлсэн: доктор, дэд профессор Ч.Амартүвшин

Хэвлэлийн эх бэлтгэл: Б.Батдалай

“Мөнхийн үсэг” ХХК-д хэвлэв.

## ГАРЧИГ

### Эрдэм шинжилгээний өгүүлэл

1. **Ф.Ийзука, М.Изухо, Б.Гүнчинсүрэн, Б.Цогтбаатар, Д.Одсүрэн.** Дорнод Монголын тал хээр болон говийн бүсэд орших шинэ чулуун зэвсгийн таван дурсгалт газрын шавар сав суулганы үйлдвэрлэлийн арга, хувьсал
2. **И Сонбук.** Рашаан хадны малтлага судалгааны зарим үр дүн
3. **Л.Яанз, Д.Бөхчулуун.** Говийн бүс нутгийн харилцаа ба нийгэмд гарсан өөрчлөлт
4. **Г.Галдан, Ч.Амартүвшин.** Умард Монголын эртний нүүдэлчдийн газар эзэмшилт (хүрэл, түрүү төмөр зэвсгийн үе)
5. **Ч.Амартүвшин, Ц.Цэлхагарав.** Монгол нутаг дахь хиргисүүрийн судалгаа
6. **З.Батсайхан, Р.Одонгоо, У.Эрдэнэбат, Ж.Хулан, Л.Вгусе.** Монголын хожуу хүрлийн үеийн соёлын асуудал ба хүн амын бүрэлдэхүүн
7. **З.Батсайхан, Р.Одонгоо, У.Эрдэнэбат, Ж.Хулан.** Хүннүгийн соёлын гарал үүсэл ба угсаатны бүлгүүд
8. **Г.Эрэгзэн.** Баруун бэлсэгийн хүннү булшнаас олдсон нумын ясан наалт ба хүннү нумын хийцийн асуудалд
9. **Ч.Ерөөл-Эрдэнэ, Я.Бемманн.** Хүнүй голын “Дөрвөлжин газар” сууринд хийсэн малтлага, холбогдох он цагийн тухай
10. **Б.Батдалай.** Хагтын хадны оршуулганаас илэрсэн хүн дүрст “Эсгий онго”

### Эрдэм шинжилгээний тэмдэглэл

11. **Рыбин Е. П., Звинс Н., Гүнчинсүрэн Б., Хаценович А. М., Пэйн К., Болорбат Ц., Одсүрэн Д., Галфи Й., Маргад-Эрдэнэ Г., Марченко Д. Е., Анойкин А. А., Ангарагдөлгөөн Г., Лхүндэв Г.** Төлбөр-12 палеолитийн дурсгалын шинэ судалгаа
12. **Г.Ангарагдөлгөөн, Д.Одсүрэн.** Сэлэнгийн сав газраас шинээр илрүүлсэн чулуун зэвсгийн дурсгалууд
13. **Д.Цэвээндорж, В.И.Молодин, Д.В.Черемисин, К.Кретэн, Л.В.Зоткина, Н.Батболд, А.Л.Нестеркина.** Монгол Алтайн нэн эртний хадны зургийн судалгаа (Цагаан салаа, Бага ойгорын дурсгалт газар)
14. **Б.Жаргалан, У.Гарднер.** Эртний нүүдэлчдийн оромж илрүүлэх малтлагын болон шинжилгээний арга зүй
15. **У.Эрдэнэбат, Д.Содномжамц.** Өгөөмөрийн хүннү булш
16. **А.Энхтөр, С.Далантай.** Шивээт-Улааны цогцолбор дурсгалын малтлага судалгааны урьдчилсан үр дүн
17. **Б.Мөрөн.** Монгол улсаас олдсон Пүгү аймгийн эзний бунхны бичээсийн монгол орчуулга тайлбар
18. **О.Ангарагсүрэн, Ё.Коүзума.** Монголын ханын зургийн хадгалалт хамгаалалтын судалгаа: Шороон Бумбагар бунхны дотоод орчны бичил цаг уурын анализ ба ханын зурагт хэрэглэсэн будгийн материалын шинжилгээ

# CONTENTS

## Papers

1. **F. Iizuka, M. Izuho, B. Gunchinsuren, B. Tsogtbaatar, and D. Odsuren.** manufacturing techniques and formal variability of pottery from five neolithic sites in eastern steppe and the Gobi desert, Mongolia
2. **Yi, Seonbok.** Excavations at Rashaan Khad – A Preliminary Report
3. **L Yanz, D.Bukhchuluun.** Expanding Frontier and Building the Sphere in Arid East Asia
4. **G.Galdan, Ch.Amartuvshin.** The land tenure of the Early Nomads in North Mongolia (Bronze and early iron age)
5. **Ch.Amartuvshin, Ts.Tselkhagarav.** Investigating the khirigsuurs in Mongolia
6. **Z.Batsaikhan, R.Odongoo, U.Erdenebat, J.Khulan, L. Bryce.** On the Late Bronze Age and composition of the population
7. **Z.Batsaikhan, R.Odongoo, U.Erdenebat, J.Khulan.** Origins of the Xiongnu culture and ethnic groups
8. **G. Eregzen.** The sticked bones of the bow discovered from Baruun Belseg tomb of the xiongnu period
9. **Ch.Yeruul-Erdene, J. Bemmann.** The walled enclosure Dörvölzhin gazar in the Khünüi valley – test excavation and dating
10. **B.Batdalai.** An anthropomorphic felt amulet

## Notes

11. **Rybin E.P., Zwyns N., Gunchinsuren B., Khatsenovich A.M., Paine C., Bolorbat Ts., Odsuren D., Galfi J., Margad-Erdene G., Marchenko D.V., Anoikin A.A, Angaragdulguun G., Lkhundev G.** The new research of the Tolbor 21 Paleolithic site (northern Mongolia) in 2017
12. **G.Angaragdulguun, D. Odsuren.** The newly found stone age sites from Selenge basin
13. **D.Tseveendorj, V.I.Molodin, D.V.Cheremisin, C.Cretin, L.V. Zotkina, N.Batbold, A.L.Nesterkina.** The study of the oldest layer of petroglyphs of Mongolian Altai (Tsagaan-Salaa and Baga-Oigor)
14. **B.Jargalan, W.Gardner.** Excavation and analysis methodologies for identifying mobile domiciles of early pastoral nomads
15. **U.Erdenebat, D.Sodnamjamts.** Xiongnu burials at Uguumur
16. **А.Энхтур, С.Далантай.** О понимальном комплексе “Шивэт-Улан”
17. **B. Murun.** Mongolian reading and explanation study on the tomb’s owner inscription of Pugu clan found in Mongolia
18. **O.Angaragsuren, Yo.Kohdzuma.** Study on the conservation of mural paintings in Mongolia: microclimate analysis of the indoor environment and scientific investigation of painting materials used in the mural painting of the Shoroon Bumbagar tomb

Л.Яанз, Д.Бөхчулуун


### ГОВИЙН БҮС НУТГИЙН ХАРИЛЦАА БА НИЙГЭМД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Товчлол. Сүүлийн үед Хятадад хэрхэн гэршүүлсэн мал амьтан болоод хүрэл боловсруулах технологи нэвтэрч эхэлсэн тухай судалгаа ихэд эрчимжиж байгаа билээ. Тэдгээр судалгаанаас харвал неолитийн сүүл, хүрлийн эхэн үед Өвөр Монголын Энээ хошууны нутаг буюу Энээ голын хөндий нь малчин нүүдэлчид болон өмнөд зүгийн газар тариаланч нарын хоорондын худалдаа, солилцооны гол суваг болж байжээ (Jaang 2015). Тэгэхлээр говийн бүс нутаг нь нүүдэлчид болон өмнөдийн суурьшмал иргэд хоорондын хамгийн эртний (НТӨ III мянган) гэж хэлж болохуйц харилцаа, худалдааны төвд тооцогдохоор юм. НТӨ II мянганы эхээс эхлэн умард болон өмнөдөөс гаралтай олдворуудын хоёр талт хөдөлгөөн илт нэмэгдэж байгаа нь Энээ голын үйлдвэрлэлтэй холбоотой хэд хэдэн дурсгалт газруудаас харагдана. Тиймээс говь нутагт амьдарч байсан хүмүүс эртний бүс нутгийн худалдаа, солилцооны сүлжээ үүсэхэд чухам ямар нөлөө үзүүлсэн гэдгийг тодруулж эхэлбэл, бид Монголын мал аж ахуйн үүслийг ойлгох боломж бүрдэх юм. Бид энэхүү судалгаандаа говийн иргэд бүс нутгийн худалдаа, солилцоо хийж байсныг харуулах баримт сэлтийг авч үзэх бөгөөд монголд мал аж ахуй урьд нь бодож байснаас хамаагүй эрт эхэлсэн гэдэг санааг дэвшүүлж байгаа юм. Үүнээс гадна, Зүүн азийн хүрлийн үеийн хөгжилд томоохон нөлөө үзүүлсэн малчин нүүдэлчдийн аж байдлыг судлахад хэрэг болох цөөн хэдэн санаа дэвшүүллээ.

Түлхүүр үг. Неолит, Хүрлийн үе, анчин түүвэрлэгчид, мал аж ахуйн үүсэл, бүс нутгийн харилцаа, худалдаа, хүрэл

Зүүн хойд Азийн археологийн судалгаанд мал аж ахуй, хүрэл боловсруулах технологийн үүсэл гарал болон сүрлэг булш бунхан байгуулж эхэлснийг нэгэн чухал үе хэмээн үздэг билээ. Монголын археологийн судалгаанд ч эдгээрийг нүүдэлчдийн угсаа гарал болоод тэдний байгуулсан төрт улсыг нэхэн судлахад нэгэн чухал эх хэрэглэгдэхүүн хэмээн үздэг. Харин өмнөд хөршийн археологийн судалгаанд эдгээрийг суурьшмал төрт улсуудын үүсэл гарлын асуудалд анхаарлаа хандуулдаг. Сүүлийн үед бүс нутгийн болон хөрш зэргэлдээ улс орнуудын археологийн судалгаанд тулгуурлан тал нутгийн нүүдэлчдийн төр болон өмнөдийн хүчирхэг, чинээлэг төрт улсуудын үүсэл гарал хоорондоо салшгүй холбоотой хэмээх онолыг судлаачид (So 1995; Linduff 2006; Shelach 2009; Honeychurch 2015; Janz et al. 2017) дэвшүүлээд

байгаа билээ. Тус онолыг бүс нутаг хоорондын соёл, эд өлгийн харилцаа, худалдаа болон дайн тулааны хүрээнд авч үздэг юм. Тал нутгийн тансаг хэрэглээ болох тэрэг, хүрэл, гоёл чимэглэлийн зүйлсээс гадна язгууртуудын сүр хүчний бэлгэдэл болсон адуунд өмнөдийн төрт улсууд нь ихэд тагагддаг байсан бол эргээд үр будаа, хүрэл толь, торго гэх мэт зүйлс нь нүүдэлчдийн сонирхолыг татаж, цаашлаад тэдний дунд нийгмийн давхраажилт үүсэхэд тодорхой үүргийг гүйцэтгэв. Хятадын төрт улсууд тал нутгаас гаралтай хүрэл боловсруулах, морь малыг уналгад ашиглах гэх мэт технологийг дотоод хэрэгцээндээ нэвтрүүлж, тэдгээрийг засаг захиргаа болоод тахил тайлгын зан үйлд ихэвчлэн ашиглаж байв. Харамсалтай нь хятадын судлаачид энэхүү өөрсдийн анхны төрт улсыг төвхнөн бий болох үйл явцад нүүдэлчдийн үүрэг оролцоо тодорхой



**Зураг 1.** 1) Орог нуур/Oroknur; 2) Баруун даваа/Baruundavan; 3) Баянзаг/Bayanzak; 4) Давст гол/Salt creek; 5) Жавхлант; 6) Дотрын намаг/Dottorenamak; 7-12, 17-19) Ингэн худаг/ Yinggenkhuduk; 13-16) Хоёр нуур/ Hoyarnur; 20-22) Маньтсар/ Mantissar; 23) Байшантан/Baishantang; 24) Хуошилиан/ Huoshiliang; 25) Ганганва/ Ganggangwa; 26) Шиченьи/ Xichengyi; 27) Донхуйшан/ Donghuishan; 28) Хуанианниантай/Huaniangniangtai; 29) Линжиа/ Linjia; 30) Бузинпин/ Buziping; 31) Фүжиамен/ Fujiamen; 32) Шижиакун/Shizhaocun; 33) Шишианпин/Xishanping; 34) Жоүжиазуанг/Zhoujiazhuang; 35) Таосы/Taosi; 36) Булан худаг/ Bulungkhuduk; 37) Өвөрмонгол; 38) Дарьганга; 39) Чандмань Хар Уул; 40) Зараа уул

хэмжээгээр байсан тухай төдийлөн бичиж тэмдэглэдэггүй билээ. Гэсэн хэдий ч сүүлийн үеийн археологийн судалгаагаар дээрх дэвшилтэд технологиуд умардын нүүдэлчин овог аймгуудаас (худалдаа/ солилцооны арга байдлаар) орж ирсэн гэдэг нь тодорхой болсоор [Honeychurch 2015; Jaang 2015].

Одоогоор Төв Азид мал аж ахуй хэрхэн бас хэзээ нэвтэрснийг баттай тодорхойлох боломж бүрдээгүй байгаа ч зэрлэг үхэр, хонь, ямааг олон мянган жилийн туршид буюу Плейстоцеины сүүлээс Голоцены эхэн үед гэршүүлж эхэлснийг Баруун Өмнөд Азид хийсэн судалгаанаас харж болно [Zeder 2011; Vigne et al. 2011]. Анатолийн хойгт НТӨ 6000 жилийн орчимд малын гаралтай сүү хэрэглэж байсан нь шавар савны хагархай дээр хийсэн липидийн<sup>1</sup> үлдэгдлийн судалгаагаар тодорхой болоод байна [Evershed et al. 2008]. Ийнхүү тариалан эрхлэгч салангид ард түмнүүдийн шилжилт хөдөлгөөний үр дүнд үхэр, хонь, ямаа Азийн баруун хэсгээр тархаж эцэст нь Европ тивд хүрсэн хэмээн судлаачид үздэг билээ [Conolly et al. 2011; Özdoğan 2011; Rowley-Conway 2011; Manning et al.

2013; Ethier et al. 2017]. Мөн Зүүн Европын газар тариалан эрхлэгч болон анчин түүвэрлэгчид НТӨ V-IV мянганыг дуустал тодорхой хэмжээнд гэршүүлсэн амьтдыг ашиглаж байгаад НТӨ IV-III мянганы үест тэдгээр гэршүүлсэн амьтад тэдний аж ахуйд гүйцэтгэх үүрэг нь илүү чухал болж эхэлснийг судлаачдын бүтээлээс харж болно [Dolukhanov 2002; Rassamakin 2002; Koryakova and Epimakhov 2007; Kotova 2008; Frachetti 2012].

Харин археологийн баримт хэрэглэгдэхүүний хомс байдлаас үүдэн бид мал аж ахуй Зүүн Азид хэрхэн нэвтэрснийг нэхэн судлахад нэлээд хүндрэлтэй хэвээр байгаа бөгөөд НТӨ IV мянганы үед Төв Азийн буюу өнөөгийн Пакистан, Энэтхэг, Тажикстан, Казахстан гэх зэрэг улсуудын газар нутагт мал аж ахуй хэдий хэмжээнд тархсан байсныг тодорхойлох боломжгүй байна [Meadow 1996; Meadow and Patel 2003; Young 2003; Razzokov 2008].

НТӨ IV мянганы адагт буюу бидний хэлж заншсанаар энеолитийн үед Хар тэнгисийн хойгуур Дон мөрнөөс Урал мөрний хоорондох өргөн тал нутагт мал болон ан агнуурын хосолмол аж ахуйтай

<sup>1</sup> Өөх, уургын хүчлийн нэгдэлийг судлах лабораторийн арга

Ямны соёл<sup>2</sup> бүрэлдэж эхэлсэн ба булш оршуулгын дурсгалаас өндгөн ёроолтой ваар сав, зэс болон хүнцэлийн (арсеник) агууламжтай хүрэл, үхэр тэрэг гэх мэт сонирхолтой олдворууд олдсон байдаг. Харин Ямны соёлтой зэрэгцэн Алтайн нурууны орчимд Афанасьевын соёлынхон нэлээд хөгжингүй болж байсан [Kislenko and Tatarintseva 1999; Kovalev and Erdenebaatar 2009; Polyakov and Svyatko 2009; Svyatko et al. 2009; Honeychurch 2015] бөгөөд энэ үеэс эхлэн адууг гэршүүлж эхэлжээ. Жишээлбэл, НТӨ 3400-3000 оны үед холбогдох Казахстаны Ботай хэмээх дурсгалт газраас олдсон олон мянган адууны ясан дээр хийсэн судалгаа, адууг гэршүүлэх үйл явц энд өрнөж байсныг харуулахаас гадна гүүний саамын үлдэгдэл ваар савны дотор талаас олдсон байна [Levine 1999; Olsen 2003, 2006; Outram et al. 2009; Bendry 2012; Frachetti 2012].

Үүнээс гадна харьцангуй бага судлагдсан Украины Дериевкагийн сууринд адууг ижил цаг үед эсвэл ялимгүй түрүү үед гэршүүлж байсан болов уу хэмээн судлаачид үздэг [Anthony and Brown 2000; Levine 1999; Warmuth et al. 2012] хэдий ч тодорхой баримт, эх хэрэглэгдэхүүн олдоогүй байна. Зүүн Азид хоёр мянган жилийн дараа буюу НТӨ II мянганы эхний хагаст гаршуулсан бог мал НТӨ II мянганы хоёрдугаар хагасаас эхлэн гаршуулсан адууны яс оршуулгын томоохон чулуун байгууламжуудаас илрэн олдсоор байна. Чухам энэ үед төмөрлөг болон мал аж ахуй нэлээд өргөн тархсан нь археологийн хэрэглэгдэхүүнээс харагддаг (Honeychurch 2015; Jaang 2015; Амартүвшин нар 2010).

<sup>2</sup> Ямны соёл – Оросын археологийн судалгаанд Ямная культура хэмээн алдарисан. Уг соёл нь НТӨ 3300-2600 оны үед буюу зэсийн сүүл, хүрлийн эхэн үед Украины өмнөд хэсгийн Буг голын хөндийгөөс Урал мөрний сав газар хүртэлх өргөн уудамд нутагт тархжээ. Уг соёлын нийтлэг чанар нь өөд бологчоо нүхэнд дээш харуулан хөлийг атийлган тавьж дээгүүр нь зос цацах ба нүхэн дээр өндөр шороон овоолго босгодог уламжлал юм. Голуу ан гөрөө хийж цөөн тооны мал малладаг гэж үзэх бөгөөд өөрсдийн багаж зэвсгийг чулуу, зэс, мод ясаар хийдэг байжээ. Ямная соёлын булинаас үхэр тэрэгийн эд анги гардгаараа нэн онцлогтой.

## Хятадын хүрлийн эхэн үеийг судалсан байдал

Зарим судалгааны бүтээлээс харахад Хятадад гаршуулсан хонь, ямаа, үхэр болон хүрэл боловсруулах технологи НТӨ III мянган эсвэл IV мянганд хамаарах боломжтой хэдий ч он цагийг хэтэрхий эрт, харьцуулалтын арга зүй нь бүрхэг байгаа тухай судлаачид нилээд шүүмжилдэг билээ. Хятадын суурьшмал газар тариаланч ард түмэн болон Евразийн тал нутгийн нүүдэлчдийн хоорондын холбоо харилцаа НТӨ II мянганы үеэс мэдэгдэхүйц өргөжиж эхэлдэг нь археологийн олон дурсгал, олдвор хэрэглэгдэхүүнээс харагддаг юм [Honeychurch 2015; Jaang 2015; Owlett 2016; Lu et al. 2017]. Умард болон Төв Хятадын дурсгалт газруудын гэршүүлсэн үхэр болон бог малын ясан дээр хийсэн генетикийн судалгаагаар эдгээр нь баруун зүгийн малтай шууд холбоотой болохыг тогтоохын зэрэгцээ он цагийг НТӨ III мянганы сүүл II мянганы эхэн үед хамааруулан авч үзсэн байдаг [Cai et al. 2011, 2014].

Өвөр Монголын Ордост неолитийн дунд үед хонь, ямаа, үхэр зэрэг мал амьтныг аж ахуйд ашиглах нь ховор, харин неолитийн хожуу үеэс (НТӨ II мянганы эхэн) эхлэн хонь, ямаа хүмүүсийн амьдралд мэдэгдэхүйц нэвтэрч эхэлсэн хэмээн үзсэн байдаг [Owlett 2016]. Мөн энэ үед нохой болон гахайн аж ахуйд эзлэх үүрэг хэвээр байж, харин хүмүүс буга агнах нь эрс цөөрч оронд нь үхэр, хонь, ямааг маллах нь ихэсжээ [Owlett 2016: Хүснэгт 1]. Үүнээс үзвэл НТӨ 2000 оны үе болоход бог мал эдийн засгийн гол бүрэлдэхүүн хэсэг болж ан агнуурыг тодорхой хэмжээнд орлох болжээ.

Хятадын археологичид НТӨ 2000-1600 жилд холбогдох дурсгалаас гэршүүлсэн үхрийн (*Bos taurus*) хөдөлшгүй ул мөр илэрч байгааг судалгааны бүтээлдээ дурдсан байдаг [Lu et al. 2017]. Үүний зэрэгцээ НТӨ 2500-2000 оны хооронд хамаарах дурсгалуудаас үхрийн яс олон тоотой илэрсэн бөгөөд тэдгээр нь хэмжээний хувьд палеолит, неолитийн сууринуудаас гарсан үхрийн яснаас жижиг байгааг судлаачид онцолдог бөгөөд энэ нь гэршүүлсэн мал байх боломжтой юм. Гэхдээ энд Хятадын Ганьсу мужийн баруун хэсгийн НТӨ 3600-2500

жилд холбогдох хэд хэдэн дурсгалуудаас гарсан үхрийн яс нь гэршүүлсэн үхрийн ястай ижил жижиг хэмжээтэй байгааг энд дурдахгүй өнгөрөөж болохгүй юм. Энэ нь генетикийн судалгаагүйгээр зэрлэг амьтан, мал хоёрыг зөвхөн явцуу харьцуулалтын аргаар ялгахад туйлын хүндрэлтэй болохыг харуулж буй хэрэг билээ. Тиймээс судлаачид Төв Хятадын умард хэсэгт орших неолитийн төгсөл үеийн Таосы (Taosi) болон Жоужанг (Zhoujiazhaung) дурсгалт газруудаас гарсан ижил хэмжээтэй яснуудыг генетикийн аргаар судлахад [Brunson et al. 2016] баруун зүгийн гаралтай гэршүүлсэн үхрийн (*Bos taurus*) ясыг Зүүн Азийн зэрлэг үхрийн ясны хамтаар мэрэг төлгийн зан үйлд өргөн ашиглаж байсныг тогтоожээ. Энэ нь ямартай ч баруун зүгээс гаралтай гэршүүлсэн мал амьтныг Хятадын төв болон хойд хэсгээр НТӨ 2500-2000 оны хооронд харьцангуй өргөн хүрээнд ашиглаж байжээ хэмээн үзэхээр байна.

Хятадын археологич Л.Жаанг (Jaang 2015) чухам энэ өөрчлөлт өрнөсөн гол газар бол өнөөгийн Хятад улсын Ганьсу, Цинхай, Нинься болон ӨМӨЗО-ны баруун хэсэг гэж тодорхойлоод энэ бүс нутгийг Эзнээ голын солилцооны бүс (Ejin River Transfer Zone) хэмээн томъёолсон байна. Эзнээ гол нь өнөөгийн Жанье хотын урд хэсгээс эх авч Алшаа говийн Гашуун нуурт цутгадаг байсан ба эрт үед урагш болон хойш урсгалтай хоёр салаа гол байжээ. Эрт цагт магадгүй голын урсгалыг ашиглан умард болон урд зүгийн хүмүүс бараа бүтээгдэхүүн солилцдог байсан бололтой.

Мөн НТӨ 3000 жилээс эхлэн улаан буудай, бог мал, үхэр, зэс болон хүрэл боловсруулах технологийг харуулах цөөн тооны баримт хэдэн газраас олджээ. Жишээлбэл, Шизаокун / Shizhaocun (бог мал – НТӨ 3000-2650 он, үхэр – НТӨ 2200-1600 он), Хэтаожуан / Hetaozhuang (бог мал – НТӨ 3200-2600 он), Фүжиаман / Fujiamen (үхэр – НТӨ 3200-2600 он), Шишиапин / Xishanping (буудай – НТӨ 2700-2400 он, үхэр 3200-2750 он), Донхуйшан / Donghuisan (буудай – НТӨ 3368-1980 он, бог мал – НТӨ 2000-1500 он), Линжиа / Linjia (хүрэл – НТӨ 2900-2750 он), Хуанианниагтай / Huangniangniangtai (хүрэл – НТӨ 2200-1600 он), Бузипин / Buziping (буудай – НТӨ 2900-

2700 он) [Jaang 2015, хүснэгт 1-3]. Дээрх он цаг бидний төсөөлөн буй он цагаас хамаагүй эрт байгаа нь харагдаж байгаа хэдий ч эдгээр он цагийг зөвхөн олдвор болон дурсгалын хэв шинжийн харьцуулсан судалгаан дээр үндэслэн гаргасан тул зарим талаар алдаатай байж болох юм.

Хүрэл эдлэл болоод гэршүүлсэн мал НТӨ 2000 оноос хойш илүү тодорч эхэлж байгаа бөгөөд НТӨ 1500 он гэхэд харьцангуй өргөн хүрээнд тархсан гэдэг нь илт байдаг. Судлаач Л. Жаангийн үзэж байгаагаар бол эдгээр үйл явдлын он цаг Алс Дорнодын төдийгүй өмнөх судлаачдын дэвшүүлсэн Төв Ази, Хятад хоёрыг холбох цорын ганц боломжит чиглэл болох Хеши хоолойн (*Hexi corridor*)<sup>3</sup> болон Шиньжаны он цагаас харьцангуй эрт байгаа юм.

Мөн түүний дэвшүүлсэн харилцааны онолын үүднээс, хүрэл боловсруулж байсан дурсгалт газрууд нэн чухал аж. Хамгийн эртнийх нь НТӨ 2200 оны орчимд хамаарах бөгөөд Эзнээ голын баруун эргээс олдсон байна (газрын нэр нь Huoshiliang, Ganggangwa). Зэргэлдээх Байшантан (Baishantang) зэсийн уурхай нь орон нутгийн зэсийн хүдэр олборлох нөөц нь байжээ [Mei et al. 2012; Dodson et al. 2009]. Харин Эзнээ голын урд биед Шичэнги (Xichengyi) хэмээх дурсгалт газраас хүрэл толь, алхны толгойн хэв олджээ [Chen et al. 2015].

Хэрэв хүрэл боловсруулах технологийн хөгжил богино хугацаанд ийм өндөр гэж хэлж болохуйц түвшинд хүрсэн юм бол үүнийг өөр бүс нутгаас ирсэн гар урчуудын оролцоо их байсан нь гарцаагүй юм. Энэхүү технологи асар хурдан нэвтрэн дэлгэрснээр шинэ соёл хүлээн авч буй ард түмний соёл, уламжлал буюу сууц болон булш бунхны бүтцэд томоохон нөлөө үзүүлэнши [Jaang 2015:195-197]. Сонирхолтой нь булш оршуулгын дурсгалаас хүрэл, зэсээр хийсэн энгийн багаж зэвсэг буюу шөвөг, хутга олдсон нь бусад өндөр хэрэгцээт

<sup>3</sup> Хятады Ганьсу мужийн нутагт дэвсгэрт орших ба Шиньжсан болон төв хятадыг холбодог түүхэн хоолой юм. Ганьсу хоолой гэх нь бас бий. Тус хоолой нь Наньшан (өмнө) болон Бэйшан уулс (хойд) дунд орших ба 1000 гаруй километр үргэлжилдэг.



бүтээгдэхүүнийг буюу Карасук хэлбэрийн хутга болон гоёл чимэглэлийн зүйлсийг шууд худалдаа, солилцооны зориулалтаар урлаж байсан болов уу хэмээн үзэж болохоор байгаа юм [Jaang 2015]. Үүнийг Шичэнги (Xichengyi) гэх мэт газраас олон тоотойгоор олдох болсон хүрэл эд зүйлс, түүний үйлдвэрлэлтэй холбоотой дурсгалуудаас гадна мал үр буудай, гэршүүлсэн мал амьтны яс (мөн тэнд), харь гаралтай шүр, явуу болон бал (graphite), оюу, чон чулуу буюу улаан мана<sup>4</sup> гэх мэт хагас үнэт чулуугаар хийсэн сувс гэрчлэх бөгөөд энэ нь зүгээр нэг тохиолдол биш ажээ [Wang and Chen 2012; Honeychurch 2015].

Мөн зарим судлаач нар уг алс холын бүлгүүдийг холбох худалдаа, солилцооны сүлжээ нь Шар мөрний дээд урсгалд орших Мацзяогийн (Maiziyaog; НТӨ 3000–2000 жил) соёлын түрүү үеэс будган чимэгтэй, өндөр хэмд шатаасан ваар савыг худалдаалах болсноор эхэлсэн хэмээн үзсэн байдаг [Jaang 2015; Janz 2017]. Мацзяогийн соёлын үйлдвэрлэлийн газруудын байршлыг харахад тухайн бүс нутагт амьдарч байсан иргэд Говийн Гашуун нуур орчмын хүмүүстэй шууд харилцах боломжтой замтай байсныг илтгэдэг. Бидэнд үүнээс улбаалан говьд суурьшиж байсан тэдгээр хүмүүс чухам ямар аж ахуй эрхэлдэг байсан бэ, үнэхээр судлаачдын [Jaang 2015, Honeychurch 2015] үзэж байгаагаар худалдаа, солилцооны хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн үү гэх зэрэг асуултууд урган гарч ирнэ. Эцэст эдгээр асуултын хариуг олохын тулд археологийн үүднээс хэрхэн судлах талаар сайтар тунгаан бодох шаардлагатай болж байна.

Тус хоёр газрын оршин суугчид НТӨ 7000 жилийн тэртээгээс ойролцоогоор НТӨ 2000 жил хүртэл ижил хэв маягаар буюу ан ав хийж, өвс ургамал түүн амьдардаг байсныг бууц суурин болон бичил чулуун зэвгийн технологи илтгэдэг [Janz et al. 2015, 2017]. Зарим тохиолдолд орон нутгийн шинж чанараас хамаараад он цаг нь өөр

өөр байх бөгөөд бичил чулуун зэвсэг дээр суурилсан анчин түүвэрлэгчид бүр НТӨ 6000-1000 жилийн хооронд амьдарч байсан байх боломж өндөр байгаа юм. Дээрх судлаачдын дэвшүүлснийг нэгтгэн үзвэл, чухам хэзээнээс гэршүүлсэн мал амьтан Умард Хятадад үзэгдэж эхэлсэн, мөн говийн малчин иргэдтэй суурьшмал иргэд чухам хэдийгээс харилцаж эхэлсэн нь ерөнхийлсөн он цаг, судалгааны явцуу арга зүй, цөөн тооны хэрэглэгдэхүүний улмаас учир дутагдалтай хэвээр байна. Тиймээс бид уг асуудлыг одоогоор мэдэгдээд байгаа археологийн хэрэглэгдэхүүнд тулгуурлан тодруулж Говийн малчин нүүдэлчид, Хятадын суурьшмал газар тариаланчидтай хэрхэн харилцаж байсныг багахан хэмжээнд тодруулахыг оролдов.

### **Бүс нутгийн харилцааг говиос эрэх нь**

Археологичид неолитийн дурсгалт газрыг тодорхойлохдоо бичил чулуун зэвсэг, шавар сав, самбар чулуу, өнгөлж зассан чулуун сүх, бифас хэлбэрийн үзүүр мэс гэх зэрэг олон олдвор хэрэглэгдэхүүнийг шалгуур болгодог билээ. Энэ төрлийн олдворууд голдуу газрын гадарга дээрээс олдох бөгөөд он цагийн хувьд төмөр зэвсгийн үе хүрэх нь бий ([НТӨ 1270-НТӨ 330]; Janz et al. 2015).

Говь нутагт чулуун зэвсгийн хүрлийн үед хэрэглэж байсан гэх нэгэн баримтыг Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутагт орших Зараа уулын суурингийн сорьц малтлагаас гарсан ваарын он цаг (радиокарбон) тогтоох шинжилгээгээр тогтоосон юм [Одсүрэн нар 2015]. Үүнээс гадна неолитийн эхэн болон сүүл үеийн хооронд зэвсэг үйлдвэрлэлд технологийн ялгаа гарсан эсэхийг тогтоон, үр дүнг бусад материалын үнэмлэхүй он цагтай харьцуулбал бас нэгэн сэжиг гарах боломжтой. Чулуун зэвсэг үйлдвэрлэлийн зарим нарийн ялгааг олох амаргүй ажил болов ч хэд хэдэн өөрчлөлтүүдийг ялган тодорхойлох боломжтой [Janz 2012; Janz et al. 2017]. Үүнд, эхлээд неолитийн сүүл үеэс эхлэн үзүүр мэс, энгийн үлдэц, өргөн болон жижиг бичил ялтас, хальцедонон (хас, цахиуртай харьцуулбал) зэвсгийн тоо олширч байгааг дурдаж болно. Чулуун багаж зэвсгээс гадна шавар сав үйлдвэрлэлийн

<sup>4</sup> Англиар “carnelian”; оросоор “карнеол”, “сердолик”. Улаан эсвэл улаан шаргал өнгийн хальцедоны төрлийн чулуу.

арга технологид багагүй өөрчлөлт гарсан байдаг. Тухайн үеийн хүмүүс суурь эсвэл ирмэгийг хэв ашиглан гаргаж, гадаргууг утсан хээ юм уу геометрийн сийлмэл дүрсээр чимэглэсэн шавар ваар сав өргөн хэрэглэдэг болсон байна (Зураг 3).

Бид [2012, 2015] энэхүү ангиллыг говийн нутгаар тархсан 100 гаруй ил сууринуудаас олдсон олдвор дээр тулгуурлан ваарны хагархай, тэмээн хяруулын өндөгний хальс гэх мэт газрын хөрсөн дээр ил байх коллагены агууламжтай эд зүйлсийг нүүрстөрөгчийн хэмжилтийн аргаар он цагийг тогтоох арга зүйг боловсруулан судлав. Говийн плейстоцены төгсгөл, голоцены үеийн он цагийг дараах байдлаар үзэх боломжтой. Түүрү неолитийн үе (НТӨ 6000-3000 жил) буюу бичил чулуун зэвсэг үйлдвэрлэгч анчин түүвэрлэгч нар говиор тархсан өвс ургамлаар арвин, чийглэг баян бүрдүүдийг түшиглэн ан ав хийж аж амьдралаа залгуулдаг байсан үе юм. Энэ үеийг байгаль цаг уурын өөрчлөлт болон хүмүүсийн аж амьдралын харилцаа холбоог дэлгэрэнгүй тайлбарлах онолын хүрээнд “Баян бүрд 2”-ын үе гэж нэрлэв. Үүний дараа хожуу неолит / энеолит (НТӨ 3000-1000 жил) буюу “Баян бүрд 3”-ын үе орох бөгөөд энэ үед тэдгээр хүмүүс анчин-түүврийн аж ахуйгаас бүрэн хөндийрөлгүйгээр гэршүүлсэн мал амьтныг аж амьдралдаа нэвтрүүлж эхэлжээ. Энэ хоёр үеийн өмнө анчин түүвэрлэгчид гол ус, чийглэг нам дор газраас гаралтай хоол хүнсийг анхлан хэрэглэж эхэлсэн үе орох бөгөөд үүнийг бидний хэлж заншсанаар мезолит / палеолитийн сүүл эсвэл бидний дэвшүүлж байгаагаар “Баян бүрд 1”-ийн үе хэмээн нэрлэж болно. Бидний удахгүй хэвлэхээр төлөвлөж буй статистикийн судалгааны ажлын үр дүнгээс цухас дурдвал, “Баян бүрд 3”-ын бууц суурин “Баян бүрд 2”-оос тооны хувьд хамаагүй цөөн, орон зайн хувьд нэлээд өргөн хүрээнд тархсан нь мэдэгдэж байна [Janz, хэвлэлтэнд].

НТӨ 1600-1000 жилийн үест говь нутгаар шоргоолжин булш, Улаан зуух хэлбэрийн булш зэрэг хүрлийн үед хамаарах шинэ маягийн оршуулгын дурсгал, Говь Гурвансайханы [Nelson 1925; Fairservis 1993, pp. 169-172; Derevianko et al. 1996, pp. 118-298; Амартүвшин нар 2015] сүрлэг

хиргисүүрийн хамтаар гарч ирсэн нь соёлын томоохон өөрчлөлтийг харуулна. Гэхдээ одоогоор эдгээр булш оршуулгын дурсгалыг Баян бүрдээр нутаглах бичил чулуун зэвсэг үйлдвэрлэгчид эсвэл шинээр шилжин ирсэн овог аймаг үйлдсэн эсэх нь тодорхойгүй байна. Гэхдээ бууц суурингийн хувьд ямар нэгэн өөрчлөлтийн талаарх баримт байхгүйгээс, неолитийн үед олон мянган жил амьдарсаар ирсэн хүмүүсийг хойч үеийнхэнтэй холбоотой болохыг үгүйсгэх аргагүй юм. Нөгөө талаас мал аж ахуй эрхлэгч нүүдэлчид шинээр суурьшсан байх магадлалтай. Үүнийг генетикийн шинжилгээний аргаас гадна бууц суурингийн өөрчлөлтөөр мөн тодруулж болох ч говийн байгаль, цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалж тэдгээр ард түмнүүдийн бууц сууринг нээн илрүүлэхэд нэлээд хүндрэлтэй байна.

Ямартай ч археологийн дурсгалд өөрчлөлт гарч байгаагаас үзвэл говь нутагт оршин суугчид гаднын соёлынхонтой харилцаа тогтоосон болох нь лавтай юм. Харин энэ мэт бүс нутгийн гэж болохоор харилцааны асуудлыг нэхэн сэргээхэд бидэнд нарийн он цагийн мэдээ чухал болох нь дамжиггүй билээ. Тиймээс радиокарбон болон термолюминесценцийн аргаар шавар ваарын он цагийг тогтоосон судалгааны [Janz et al. 2015] үр дүнгээс үзвэл говийн дурсгалт газрууд ерөнхийдөө НТӨ 3000 – 1500 (хүснэгт 1, зураг 1) жилийн хооронд холбогдож байна. Үүнээс гадна цөөн хэдэн дурсгалт газарт хүмүүс нэлээд эрт үеэс эхлэн амьдарч байжээ. Жишээлбэл, Өвөр Монголын Алшаа говийн Ингэн худаг хэмээх газрын ваарын хагархай НТӨ 4590-3150 жил, харин Өмнөговь аймгийн Булган сумын нутаг дахь Баянзагийн дурсгалт газрын ваар нь НТӨ 4430-3190 жил гэж заажээ. Мөн ваар болон чулуун зэвсгийн төрөл зүйлийн ангиллыг харвал дээрх дурсгалт газраас өөр олон тооны ил суурин “Баян бүрд 3” буюу энеолитийн үед хамаарч байна. Бидний энэхүү судалгаанд говийн баруун хэсгээс (Монгол, Өвөр Монголын нутаг) илэрсэн дурсгалууд илүү хамааралтай юм (Хүснэгт 2).

Ижил шавар зуурмагаар урлаж, гадаргыг хар өнгийн хээгээр чимэглэн маш өндөр хэмд шатаасан, улаан өнгийн

ваарын хагархай (Зураг 3) Алшаа говийн дурсгалуудад нийтлэг тохиолдож байна. Мөн ийм төрлийн шавар савны үлдэгдэл Ингэн худаг, Хоёр нуурын ил суурингуудаас олддог. Харин хар будган хээтэй ваарын хагархай нь голдуу баруун талаараа буюу Эзнээ голоор зааглагдсан Гурнайн хотгорын зүүн захаар байх Ух тохойн сүм (Ukh-Tokhoi), Маньтсар (Mantissar) гэх мэт газруудаас олдсон бөгөөд эдгээр нь Хуошилиан (Huoshiliang), Ганганва (Ganggangwa) зэрэг хүрэл боловсруулах газруудаас зуу орчим километрийн зайд оршиж байгаа нь тун сонирхолтой юм. Үүгээр ч зогсохгүй тэмээн хяруулын өндөгний хатуу хальсаар их хэмжээний сувс дагнан үйлдвэрлэж байсныг илэрхийлэх чулуун багаж зэвсэг, зэс, хүрлийн хаягдал, чулуужсан мод, зассан оюу чулууны үлдэгдэл гэх мэт үйлдвэрлэлтэй холбоотой олдвор хэрэглэгдэхүүн олон арваараа олджээ. Мөн дээр дурдсан хар хээтэй, улаан өнгийн ваар Баянзагийн дурсгалт газар болон өөр хэд хэдэн газраас олдсон гэх мэдээ бий [Окладников 1962, Сибиктаров 2002]. Мөн Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Зараа уулын давхаргат сууринд хийж буй малтлагаар дээрхтэй адилхан ваарын хагархай гарсныг энд дурдах нь зүйтэй. Ийнхүү ижил төрлийн ваар говийн энэ өргөн уудам нутагт тархсан байгаа нь Мацзяогийн (Maizhijiao) соёлынхон умардад аж төрөх хөршүүдтэйгээ худалдаа, солилцоо идэвхитэй хийж байсан гэх судлаачдын саналыг давхар баталгаажуулж байна.

“Баян бүрд 3”-ын үед сав суулганаас гадна, өндөгний хальс, хагас үнэт чулуугаар хийсэн төрөл бүрийн сувсыг худалдаалах явдал нэмэгдэж, зарим талаар худалдааны чухал нэгж болж байсан нь Шиченжи (Xichengyi) дурсгалт газрын судалгааны эх хэрэглэгдэхүүнээс [Jaang 2015:194; Janz 2012] тодорхой мэдэгдэнэ. Төв Азийн тэмээн хяруул “Баян бүрд 2”-ын үед мөхсөн хэмээн үзсэн хэдий ч олон тооны “Баян бүрд 3”-т хамаарах археологийн дурсгалуудаас өндөгний хальсаар сувс хийж байсныг илтгэх олон зуун бүтэн сувс үйлдвэрлэлийн хаягдлын хамт олдсон байдаг. Түүгээр ч барахгүй чулуун сувсны орон нутгийн шинж чанарыг агуулсан үйлдвэрлэлтэй холбоотой шинэ баримт

сэлт гарч ирсээр байгаа нь бус нутгийн харилцааг ойлгоход чухал үүрэг гүйцэтгэх юм. Үүнийг жишээлбэл Шан болон Жоу улсын язгууртны булш бунхнаас тусгай арга ухаан шаардагдан хийх улаан манан зүүлт олон тоогоор гарсантай холбон тайлбарлаж болох юм. Судлаачид энэхүү зүүлтний түүхий эд Хятадад байхгүй учир тэдгээрийг Энэтхэгийн Инд мөрний хөндийгөөс гаралтай гэсэн санааг дэвшүүлсэн байдаг [Peng and Zhu 1999; Rawson 2010] нь говийн чулуулаг хийгээд археологийн тухай дутмаг ойлголтоос үүдсэн дүгнэлт хэмээн үзэж болно. Учир нь говьд шар, улаан өнгийн мана элбэг тохиолдохоос гадна түүнийг бусад гоёмсог чулуунуудын хамтаар засаж, янзлан хэрэглэж байсан баримт олон байна [Амартүвшин нар 2015].

Мөн 1930-аад оны үед Хятад-Шведийн экспедицийн Алшаа говиос нээн илрүүлсэн сувсны үйлдвэрлэлтэй холбоотой нэгэн агуйн дурсгалын судалгааг энд дурдаж болно [Janz 2017]. Энэхүү газрыг Ух тохой (Ukh-Tokhoi) хэмээх бөгөөд судлаачид үүнийг ямар нэг сүсэг бишрэлийн зан үйлтэй холбоотой дурсгал хэмээн тодорхойлсон байдаг. Агуй дотроос нь ваар сав, дуусгаагүй үлдээсэн халцедонон сувсны хэсэг, дунд зэрэг хэмжээтэй цөөн хэдэн ховил бүхий хавтан чулуун (элсэн чулуу, хайлуур жоншоор хийсэн) хамт гарсан байна. Сонирхолтой нь жижиг чулуун сувснууд хавтанд байх жижиг ховилд таарч байсан тухай судлаачдын тайлан эх хэрэглэгдэхүүнд өгүүлсэн байдаг [Maringer 1950: 110, Figure 32, Plate XXX-VIII, 1952]. Мөн 1925 онд ижил хэлбэрийн боловч чулуужсан модоор хийсэн ховилтой хавтан чулууг Өвөр Монголын Алтат, Ар Монголын Баянзагаас (Зураг 4) тус тус олдож байжээ [Fairservis 1993: 41, Figure 14]. Тэгэхээр дээрх ховилтой хавтан чулуу нь магадгүй чулуун зүүлт хийхэд ашиглаж байсан хэмээн үзэж болох хэдий ч өмнөх судлаачдын сумны шилбэ тэгшлэх зориулалттай чулуун хавтан гэсэн саналыг энд давхар дурдах нь зүйтэй.

Эцэст нь говиос гаралтай улаан манаар хийсэн сувснууд нь хоёр бүс нутгийн худалдааны шинжтэй харилцааг тодорхой хэмжээнд тодруулж өгч байгааг онцлон тэмдэглэхийн зэрэгцээ сувс үйлдвэрлэгч

нар буюу говийн анхны малчид өөрсдөө ч тэдгээр сувсыг гоёл чимэглэлдээ өргөн ашиглаж байсан нь тодорхой билээ [Амартүвшин нар 2016; Амартүвшин нар, 2015].

### **Мал аж ахуй ба Говийн бүс нутаг**

Нүүдэлчид болон Хятадын суурин газар тариалан эрхлэгч нар хамгийн эртдээ НТӨ 2200-2000 жилийн орчмоос бүс нутгийн хүрээнд төвлөрөн харилцдаг байсныг Алшаа говь болон Говь-Алтай зүүн хэсгээр хийгдсэн олон тооны судалгааны ажлын үр дүнгээс харж болно. Гэхдээ бид бүс нутгийн худалдаа, технологийн солилцоог “Баян бүрд 3”-ын дурсгалуудаас гарах төмөрлөгийн баас, өндөр хэмд шатаасан шавар савны үлдэгдэл бүрэн харуулах баримт биш гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Энэ асуудлыг бид гүйцэт ойлгохын тулд говь нутагт мал аж ахуй чухам хэзээ эхэлснийг тодруулах шаардлагатай ч гэршүүлсэн мал амьтантай холбоотой хэрэглэгдэхүүн НТӨ II мянганаас өмнөх цаг үеийн дурсгалуудаас бараг олдоогүй байна. Харин хиргисүүр, буган хөшөө болон түрүүлгэ нь харуулсан булш оршуулгын дурсгалууд гарч ирснээр энэ асуудлыг тодорхой хэмжээнд тайлбарлах боломж үүсэж байгаа юм [Наваан 1975; Fitzhugh 2009; Гүнчинсүрэн нар 2012; Tumen et al. 2014; Honeychurch 2015].

